



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/69/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2024 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас: 70373089, 99023682

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас: 99023682

Цахим хаяг: [batsurenu@audit.gov.mn](mailto:batsurenu@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 99377479

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Захирал: Б.Жаргалсайхан

Утас: 99862066

Цахим хаяг: [peakomaudit@gmail.com](mailto:peakomaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ М.СОЁЛМАА ТАНАА

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Бодс, од. дс № 139

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 36.9 хувиар өссөн байна.

4525020236

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж .....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	166,360,368.41	297,904,082.93
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	109,832,453.41	228,792,831.93
31210	Төгрөг	109,832,453.41	228,792,831.93
31211	Төрийн сангийн харилцах	109,832,453.41	228,792,831.93
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	56,527,915.00	69,111,251.00
35100	<b>Түүхий эд материал</b>	2,298,320.00	2,298,320.00
35130	Эм боох материал	2,298,320.00	2,298,320.00
35400	<b>Хангамжийн материал</b>	54,229,595.00	66,812,931.00
35410	Бичиг хэргийн материал	1,156,000.00	1,126,000.00
35420	Аж ахуйн материал	38,924,560.00	33,471,560.00
35450	Барилгын засварын материал	1,589,000.00	165,000.00
35460	Хүнсний материал	6,730,185.00	14,496,127.00
35470	Бусад хангамжийн материал	5,829,850.00	17,554,244.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,411,810,186.50	1,460,546,583.86
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,411,810,186.50	1,460,546,583.86
39200	<b>Биет хөрөнгө</b>	1,282,110,186.30	1,330,153,583.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,368,949,523.00	1,364,857,123.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,227,113.59)	(159,864,742.51)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	48,791,070.00	125,506,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,119,850.92)	(24,338,203.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,834,398.07	55,046,922.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,327,284.96)	(37,463,193.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,155,300.00	8,155,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,326,335.30)	(2,841,602.34)
39217	Ном	1,380,480.00	1,095,780.00
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	129,700,000.20	130,393,000.02
39301	Програм хангамж	1,124,300.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,299.80)	(76,999.98)
39303	Бусад биет бус хөрөнгө	129,700,000.00	129,700,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,578,170,554.91	1,758,450,666.79
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,578,170,554.91	1,758,450,666.79
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,578,170,554.91	1,758,450,666.79
51100	Засгийн газрын оруулсан капитал	469,207,470.20	469,207,470.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	469,207,470.20	469,207,470.20
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	733,221,051.60	913,501,163.48
51210	Өмнөх үеийн үр дүн	658,460,460.85	733,221,051.60
51220	Тайлант үеийн үр дүн	74,760,590.75	180,280,111.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	375,742,033.11	375,742,033.11
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,578,170,554.91	1,758,450,666.79

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>896,552,012.47</b>	<b>1,162,405,600.00</b>
118304	Нохойны албан татвар	0.00	0.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>83,297,113.00</b>	<b>91,260,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>83,297,113.00</b>	<b>91,260,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>35,000.00</b>	<b>7,566,500.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	7,566,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,740,000.00	80,047,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	79,522,113.00	3,646,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>813,254,899.47</b>	<b>1,071,145,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>768,942,500.00</b>	<b>1,021,445,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	768,942,500.00	1,021,445,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>44,312,399.47</b>	<b>49,700,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,312,399.47	49,700,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>821,791,421.72</b>	<b>981,840,788.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>821,791,421.72</b>	<b>981,840,788.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>811,658,921.72</b>	<b>970,244,376.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>480,820,885.21</b>	<b>658,425,303.35</b>
210101	Үндсэн цалин	325,601,369.84	477,693,211.35
210102	Нэмэгдэл	136,346,499.37	167,343,292.00
210104	Урамшуулал	18,873,016.00	13,388,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,107,168.78</b>	<b>83,612,066.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,115,822.78	57,077,799.13
210202	Тэтгэмжийн даатгал	4,837,157.00	6,720,554.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,858,726.00	3,350,324.00
210204	Ажилгүйдлийн даатгал	936,549.00	3,301,419.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,358,914.00	13,161,970.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,012,399.47</b>	<b>36,378,888.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,960,306.69	11,423,911.79
210302	Түлш, халаалт	13,280,192.12	11,767,831.46
210303	Цэвэр, бохир ус	13,771,900.66	13,187,145.05
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>91,830,695.00</b>	<b>102,440,328.00</b>
210502	Хоол, хүнс	91,830,695.00	102,440,328.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>65,107,443.00</b>	<b>12,500,000.00</b>
210604	Урсгал засвар	65,107,443.00	12,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,558,800.00</b>	<b>2,046,682.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,558,800.00	2,046,682.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,221,530.26</b>	<b>74,841,108.64</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,015,996.00	16,430,806.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,820,000.00	9,185,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,385,534.26	49,225,002.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,132,500.00</b>	<b>11,596,411.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,132,500.00</b>	<b>10,775,300.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,132,500.00	10,775,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>821,111.70</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	821,111.70
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>74,760,590.75</b>	<b>180,564,811.88</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>284,700.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	284,700.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>74,760,590.75</b>	<b>180,280,111.88</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	813,289,899.47	1,071,145,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	813,254,899.47	1,071,145,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	768,942,500.00	1,021,445,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	768,942,500.00	1,021,445,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,312,399.47	49,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,312,399.47	49,700,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	713,680,913.46	946,833,121.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,680,913.46	946,833,121.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	703,548,413.46	935,236,709.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,820,885.21	658,425,303.35
210101	Үндсэн цалин	325,601,369.84	477,693,211.35
210102	Нэмэгдэл	136,346,499.37	167,343,292.00
210104	Урамшуулал	18,873,016.00	13,388,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,107,168.78	83,612,066.13
210201	Тэтгэврийн даатгал	41,115,822.78	57,077,799.13
210202	Тэтгэмжийн даатгал	4,837,157.00	6,720,554.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,858,726.00	3,350,324.00
210204	Ажилгүйдлийн даатгал	936,549.00	3,301,419.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,358,914.00	13,161,970.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,012,399.47	36,378,888.30
210301	Гэрэл, цахилгаан	9,960,306.69	11,423,911.79
210302	Түлш, халаалт	13,280,192.12	11,767,831.46
210303	Цэвэр, бохир ус	13,771,900.66	13,187,145.05
2105	Нормативт зардал	89,753,260.00	110,206,270.00
210502	Хоол, хүнс	89,753,260.00	110,206,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,300,000.00	12,500,000.00
210604	Урсгал засвар	7,300,000.00	12,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,558,800.00	2,046,682.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,558,800.00	2,046,682.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,995,900.00	32,067,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,319,400.00	21,292,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,676,500.00	10,775,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,132,500.00	11,596,411.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,132,500.00	10,775,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,132,500.00	10,775,300.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	821,111.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	821,111.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	99,608,986.01	124,312,478.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	5,352,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,352,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,352,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,352,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(5,352,100.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	99,608,986.01	118,960,378.52
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,223,467.40	109,832,453.41
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	109,832,453.41	228,792,831.93

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	658,460,460.85	1,503,409,964.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	658,460,460.85	1,503,409,964.16
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	74,760,590.75	74,760,590.75
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	733,221,051.60	1,578,170,554.91
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	733,221,051.60	1,578,170,554.91
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	733,221,051.60	1,578,170,554.91
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	180,280,111.88	180,280,111.88
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	913,501,163.48	1,758,450,666.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,193,537,900.00</b>	<b>951,364,109.78</b>	<b>(242,173,790.22)</b>	<b>79.7</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,193,537,900.00</b>	<b>951,364,109.78</b>	<b>(242,173,790.22)</b>	<b>79.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,182,762,600.00</b>	<b>940,588,809.78</b>	<b>(242,173,790.22)</b>	<b>79.5</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>856,401,200.00</b>	<b>658,425,303.35</b>	<b>(197,975,896.65)</b>	<b>76.9</b>
210101	Үндсэн цалин	630,493,900.00	477,693,211.35	(152,800,688.65)	75.8
210102	Нэмэгдэл	216,774,200.00	167,343,292.00	(49,430,908.00)	77.2
210104	Урамшуулал	9,133,100.00	13,388,800.00	4,255,700.00	146.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>98,538,000.00</b>	<b>83,612,066.13</b>	<b>(14,925,933.87)</b>	<b>84.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,007,900.00	57,077,799.13	(9,930,100.87)	85.2
210202	Тэтгэмжийн даатгал	7,880,800.00	6,720,554.00	(1,160,246.00)	85.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,941,500.00	3,350,324.00	(591,176.00)	85.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,941,500.00	3,301,419.00	(640,081.00)	83.8
210205	Эрүүл мэндийн даатгал	15,766,300.00	13,161,970.00	(2,604,330.00)	83.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,759,900.00</b>	<b>36,378,888.30</b>	<b>(13,381,011.70)</b>	<b>73.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,462,800.00	11,423,911.79	(4,038,888.21)	73.9
210302	Түлш, халаалт	16,519,300.00	11,767,831.46	(4,751,468.54)	71.2
210303	Цэвэр, бохир ус	17,777,800.00	13,187,145.05	(4,590,654.95)	74.2
2105	<b>Нормативт зардал</b>	<b>117,751,400.00</b>	<b>110,206,270.00</b>	<b>(7,545,130.00)</b>	<b>93.6</b>
210502	Хоол, хүнс	117,751,400.00	110,206,270.00	(7,545,130.00)	93.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,500,000.00</b>	<b>12,500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	12,500,000.00	12,500,000.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,386,200.00</b>	<b>2,046,682.00</b>	<b>(1,339,518.00)</b>	<b>60.4</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,386,200.00	2,046,682.00	(1,339,518.00)	60.4
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,425,900.00</b>	<b>37,419,600.00</b>	<b>(7,006,300.00)</b>	<b>84.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,650,600.00	26,644,300.00	(7,006,300.00)	79.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,775,300.00	10,775,300.00	0.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,775,300.00</b>	<b>10,775,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,775,300.00</b>	<b>10,775,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,775,300.00	10,775,300.00	0.00	100.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,193,537,900.00</b>	<b>1,070,324,488.30</b>	<b>(123,213,411.70)</b>	<b>89.7</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,021,445,600.00</b>	<b>1,021,445,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,021,445,600.00	1,021,445,600.00	0.00	100.0
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>62,259,900.00</b>	<b>48,878,888.30</b>	<b>(13,381,011.70)</b>	<b>79.8</b>
320001	Орон нутгийн төсвөөс	62,259,900.00	48,878,888.30	(13,381,011.70)	79.8
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	109,832,400.00	0	(109,832,400.00)	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	109,832,453.41	109,832,453.41	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	228,792,831.93	228,792,831.93	100.0
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>32.00</b>	<b>(3.00)</b>	<b>91.4</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0

620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	24.00	(2.00)	92.3
620003	Үйлчлэх ажилтан	8.00	7.00	(1.00)	87.5
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>287.00</b>	<b>250.00</b>	<b>(37.00)</b>	<b>87.1</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	287.00	250.00	(37.00)	87.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэг "Хүүхдийн эрүүл мэнд, танин мэдэхүйн хөгжлийг дэмжиж, хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, бүх талын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлж сурах тэгш боломж бүрдүүлэн сургалт үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ агуулгын тохируулга сайжруулалтыг хийж чанартай сургалтыг зохион явуулах
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зураг, дүрс, тэмдэг тэмдэглэгээний утга санааг ойлгох хүүхдийг сургуульд бэлтгэх, хамтын үйл ажиллагааг сайжруулах өдөр тутмын хичээл сургалтыг үр дүнтэй чанартай явуулах
- Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг өөрийн цэцэрлэгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн зохион байгуулан, үнэлгээ судалгаанд үндэслэн багшийг чадвахжуулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх
- Байгууллагын багш ажилтаны ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн сахиж, мэргэжлийн бие даасан байдлыг хүндэтгэсэн харилцаа хандлагыг бий болгож сэтгэл зүйн таатай орчинг бүрдүүлэн, эцэг эх- олон нийтийн оролцоог сайжруулж сурах, сургах үйлийг дэмжсэн байгууллага болох
- Үндэсний болон орон нутгийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг багш ажилтныг мэргэжлийн онол арга зүйн чадамжийг сайжруулахад чиглүүлж ахиц үр дүнг тооцох
- Хүүхдийн сурах хэрэгцээ шаардлагад тулгуурлан "ЗУРАГТ НОМ" Төсөлт ажлыг хэрэгжүүлэн үр дүнг тооцох нээлттэй тайлагнах
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулж тэдний онцлог хэрэгцээнд суурилан хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан дэмжлэгийн багц үйл ажиллагааг сайжруулах
- Цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгаалал эрүүл аюулгүй орчин бий болгож "НЭГДҮГЭЭР ХҮҮХЭД" – арга хэмжээг сайжруулан хэрэгжүүлэх
- Хүүхдийн сурах үйлийг дэмжин, сургалтын нэмэлт хөтөлбөр аюулгүй амьдрах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн гамшгаас хамгаалах төсөлт ажлыг хэрэгжүүлэн үр дүнг тооцох
- Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, орон нутгийн оролцоо дэмжлэгт тулгуурлан "ӨДӨР БҮР-СҮҮ" төслийг боловсруулан хэрэгжүүлж хүүхдийн өсөлт эрүүл мэндийг дэмжих

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын

гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;

- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дугаар тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 180,280.1 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	109,832.4	228,792.8	118,960.4
Бараа материал	56,527.9	69,111.2	12,583.3
Үндсэн хөрөнгө	1,411,810.2	1,460,546.6	48,736.4
Нийт хөрөнгө	1,578,170.5	1,758,450.6	180,280.1
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,578,170.5	1,758,450.6	180,280.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,578,170.5	1,758,450.6	180,280.1

2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 69,111.2 мянган төгрөг болж 12,583.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 148,667.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 136,084.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,460,546.6 мянган төгрөг болж 48,736.4 мянган төгрөгөөр өссөн байна. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,352.1 мянган төгрөгийн телевизор, хөлдөөгч, хандиваар Дархан-Уул аймгийн Боловсролын газраас 17,239.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 04 өдрийн 01-А/491 тоот захирамж, Засаг даргын 2024 оны 12 сарын 30 өдрийн 01-А/524 тоот захирамж орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн угаалгын тоног төхөөрөмж, 14,468.0 мянган төгрөгийн телевизор, хурлын заалны өсгөгч, яригч, 40,000.0 мянган төгрөгийн шарах зуух, хоолны тогоо нийт 80,047.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20 өдрийн А/16 тоот тушаалаар 14,696.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг шинэчлэн тогтоож 6,946.5 мянган төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 01 өдрийн А/35 тоот тушаалаар 824.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг шинэчлэн тогтоож 620.0 мянган төгрөгөөр орлого авсан, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20 өдрийн А/17 тоот тушаалаар 5,280.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансны ангилал шилжүүлэн бүртгэж, аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 14,529.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацаанд 49,225.0 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,758,450.6 мянган төгрөг болж 180,280.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 889,695.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 82,759.8 мянган төгрөг, нийт зарлагыг 972,455.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 284,923.9 мянган төгрөгөөр бууруулж 604,771.9 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 20,499.9 мянган төгрөгөөр бууруулж 62,259.9 мянган төгрөг, нийт 667,031.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 526,506.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон бол орон нутгийн төсөвт тодотгол хийгээгүй байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,021,445.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 109,832.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 62,259.9 мянган төгрөг, нийт 1,193,537.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,021,445.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 49,700.0 мянган төгрөг, нийт 1,071,145.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 951,364.1 мянган төгрөг буюу 79.7 хувьтай зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 821.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 118,960.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

д/ д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	71801	Сургуулийн өмнөх боловсрол				
			1,193,537.9	951,364.1	(242,173.8)	79.7
1	80111	Тогтмол зардал	62,259.9	48,878.9	(13,381.0)	78.5
2	80233	Хүүхэд хамгаалал	2,766.8	1,580.2	(1,186.6)	57.1
3	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	13,842.8	1,377.0	(12,465.8)	9.9
4	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	106,395.2	110,206.3	3,811.1	103.6
5	81816	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	4,492.0	4,492.0	0.0	100.0
6	81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,486.6	960.0	(1,526.6)	38.6
7	81834	Боловсролын стандарт	977,165.3	759,740.4	(217,424.9)	77.7
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	24,129.3	24,129.3	0.00	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд 2 удаа зарласан боловч тендер харилцагч орж ирээгүй учир ТБОНӨХБАУХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан

удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 823,717.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,474.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 255,277.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	255,277.6	4	255,277.6	100
Нийт дүн	4	255,277.6	4	255,277.6	100

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 127,648.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 119,598.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 5,258.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж 2,791.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

##### 5.1 Залруулсан алдаа

- 2024 оны санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үр дүнг 119,460.9 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан
- Дахин үнэлсэн 138.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшилын дансанд бүртгэсэн.нь Энэ нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 10 дугаар бүлэг "Ангилал", "Толилуулга", батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг залруулав.

##### 5.2 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

##### 5.3 Албан шаардлага

Цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,258.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв..

##### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Тус сургууль нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2 Бараа материалын тайлан, орлого зарлагыг түүвэрлэн шалгахад 2,791.4 мянган төгрөгийн бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" 10 дугаар хавсралт "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" заалтуудыг зөрчсөн ба "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Бараа материалыг зөв ангилан бүртгэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн

3. Ур чадварын нэмэгдэлийн шалгуур үзүүлэлт, нэмэгдэл олгох журам боловсруулан төсвийн шууд захирагчаар батлуулаагүй байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, "Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, нэмэгдэл олгох журам боловсруулан ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн	1	119,460.9			1	119,460.9	1	119,460.9				
Дансны ангилал буруу бүртгэсэн.	1	138.0			1	138.0	1	138.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>119,598.9</b>			<b>1</b>	<b>119,598.9</b>	<b>1</b>	<b>119,598.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалт ай давхардуулан олгосон	1	5,258.0			1	5,258.0				
Ур чадварын нэмэгдэлийн шалгуур үзүүлэлт, нэмэгдэл олгох журам боловсруулан төсвий	1	0.00					1	0.00		
Бараа материалын ангилал буруу бүртгэсэн	1	2,791,4					1	2,791,4		
Ахмадын сан байгуулаагүй	1	0.00					1	0.00		
	<b>4</b>	<b>8,187.4</b>			<b>1</b>	<b>5,258.0</b>	<b>3</b>	<b>2,791,4</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй	1	0.00					1	0.00
Дүн	1	0.00					1	0.00
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.00</b>					<b>1</b>	<b>0.00</b>



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 12 сар 25 өдөр

Дугаар 01/57-24010611-2025/69/КА-07А ТУЗ Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,258,000.00 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж, мөнгөн урамшуулал давхардуулан олгох зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч М.Соёлмаа, нягтлан бодогч Б.Энхзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

С.БАТЦЭЦЭГ

А.БАТБОЛД

4525040153